



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 05 сарын 19 өдөр

Дугаар 270

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга
хэмжээний тухай

“Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг зөрчиж худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй 497.7 сая төгрөгийн худалдан авалт хийсэн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 176 дугаар тогтоолоор батлагдсан хөрөнгө оруулалтын зардлыг 1,013.8 сая төгрөгөөр хэтрүүлсэн, “Түрээсийн төлбөрийн доод үнэ, гэрээний үлгэрчилсэн загвар батлах тухай” Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 102 дугаар тогтоолын заалтыг зөрчиж 25.3 сая төгрөгийн түрээсийн төлбөрийг төсөвт төвлөрүүлээгүй, Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.8 дахь заалтыг зөрчиж 222.0 сая төгрөгийн ногдол ашгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалтыг зөрчиж 43.5 сая төгрөгийн арга хэмжээг бүрдэл дутуу баримтаар санхүүжүүлсэн, Арилжааны банканд мөнгөн хөрөнгийн чөлөөт үлдэгдлийг хадгаламжийн хэлбэрээр байршуулахдаа Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа эрсдэлгүй, өгөөжтэй банкыг сонгон шалгаруулалтын аргаар сонголтгүй 7,891.3 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийг байршуулсан зэрэг нийт 11,077.4 сая төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглэж, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэн 2020 оны 2 дугаар улиралд багтаан төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт танилцуулахыг “Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд зөвлөсүгэй.

2.1 “Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанийн 2018 он, 2019 оны эхний 10 сарын санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, шалгалтын мөрөөр зохион байгуулах ажлын төлөвлөгөөг хянан баталж, хэрэгжилтийг хангаж ажиллах;

2.2 Шалгалтаар их хэмжээний зөрчил дутагдал гаргаж, хуулиар хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлж ажилласан “Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанийн ерөнхий нягтлан бодогч болон холбогдох бусад албан тушаалтанд Хөдөлмөрийн тухай хуулийн 131 дүгээр зүйлд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах;

300407

3. “Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанийн төрийн өмчит хувьцаат компанийн захирал Р.Батсүхэд санхүүгийн сахилга батыг хэвшүүлж, дотоод хяналтыг сайжруулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай:

3.1 Шалгалтын тайланд дурдсан зөрчил, дутагдлыг арилгах төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж ажиллах;

3.2. Худалдан авах ажиллагаанд “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хууль, Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг мөрдөж ажиллах;

3.3. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 3-д “Төрийн өмчит хуулийн этгээд үл хөдлөх хөрөнгийг захиалгын үндсэн дээр зөвхөн төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэрээр олж авна” гэсэн заалтыг мөрдөж, зорилтот түвшингийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй хөрөнгө худалдан авахыг таслан зогсоох;

3.4. Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг хуулийн этгээд, иргэдэд түрээслүүлснээс олсон орлогын 30 хувийг улсын төсөвт төвлөрүүлж ажиллах, 2018 онд төсөвт төвлөрүүлээгүй 25.8 сая төгрөгийн түрээсийн орлогыг 2020 оны 2 дугаар улиралд багтаан төсөвт төвлөрүүлэх;

3.5. Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн талаар авах арга хэмжээний тухай Засгийн газрын 2018 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн 8 дугаар тогтоолын 2.2-д төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээс дээд шатны байгууллага, төрийн захиргааны байгууллагын зардлыг санхүүжүүлэхийг таслан зогсоох, зөрчсөн албан тушаалтанд хуулийн хүрээнд арга хэмжээ авч байхаар заасныг мөрдөж ажиллах,

3.6. Компанийн 2017 оны санхүүгийн тайлангийн цэвэр ашгийн дүнгээс төсөвт бүрэн төвлөрүүлээгүй байгаа 222.0 сая төгрөгийг ногдол ашгийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан төсөвт төвлөрүүлэх;

3.7. Гадаад, дотоод албан томилолтын хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулж, эрх бүхий байгууллага, удирдах албан тушаалтны удирдамж, томилолтгүй ажиллагдийг таслан зогсоох;

3.8. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалтыг зөрчин санхүүгийн бүрдэл дутуу баримтаар хийгдсэн ажил гүйлгээний баримтыг нөхөн бүрдүүлж, шалгуулах,

3.9. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, зөрчил дутагдал гаргасан, хяналт тавих үүргээ хангалтгүй биелүүлсэн ажилтан, албан тушаалтанд хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцож, 2020 оны 2 дугаар улиралд багтаан биелэлтийг ирүүлэх;

4. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт, шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫН ХЭЛТЭСИЙН
ДАРГА




З.МЭНДСАЙХАН

Ц. ТҮВШИНЗАЯА

300406

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
2020 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн
270 дугаар тогтоолын хавсралт



Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал, түүнийг арилгах арга хэмжээний жагсаалт

№	Зөрчил, дутагдлын утга	Хариуцах эзэн	Дүн /мян.төгрөг/	Зөрчил-дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Гэрээ хэлцэлгүй худалдан авсан ажил үйлчилгээ	Захирал Р.Батсүх, Ерөнхий ня-бо Д.Даваадорж	23,274.4	Монгол Улсын Иргэний хуулийн холбогдох заалтыг мөрдөж ажиллах
2	Компанийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй худалдан авалт	Захирал Р.Батсүх, Ерөнхий ня-бо Д.Даваадорж	497,706.37	Холбогдох журмыг мөрдөж ажиллах
3	Төлөвлөгөөнөөс хэтрүүлэн зарцуулсан үл хөдлөх хөрөнгө	Захирал Р.Батсүх, Ерөнхий ня-бо Д.Даваадорж	1,013,820.6	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг мөрдөж ажиллах
4	Үндсэн баримтгүй зарцуулсан хөрөнгө	Захирал Р.Батсүх, Ерөнхий ня-бо Д.Даваадорж	43,481.26	Монгол Улсын нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1.4-д заасан "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" заалтыг мөрдөж ажиллах
5	Байгууллагын үйл ажиллагаатай холбоогүй үргүй зардал	Захирал Р.Батсүх, Ерөнхий ня-бо Д.Даваадорж	1,240,104.90	Монгол Улсын "Төсвийн тухай хууль"-ийг мөрдөж ажиллах
6	Төсөвт төвлөрүүлээгүй ногдол ашиг	Захирал Р.Батсүх, Ерөнхий ня-бо Д.Даваадорж	222,033.00	ТӨБЗГ-ын 2016 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 101 дүгээр тогтоолыг мөрдөж ажиллах
7	Төсөвт төвлөрүүлээгүй түрээсийн төлбөр	Захирал Р.Батсүх, Ерөнхий ня-бо Д.Даваадорж	25,800.00	ТӨБЗГ-ын 2016 оны н 102 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах
8	Сонгон шалгаруулалт хийхгүйгээр арилжааны банкуудад байршуулсан мөнгөн хөрөнгө	Захирал Р.Батсүх, Ерөнхий ня-бо Д.Даваадорж	7,891,261.61	Сонгон шалгаруулалт явуулж, Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож ажиллах,
9	Гадаад албан томилолтын журам зөрчсөн	Захирал Р.Батсүх, Ерөнхий ня-бо Д.Даваадорж	26,663.08	Албан томилолтын журмыг мөрдөж ажиллах
10	Үр ашиггүй зарцуулагдсан сургалтын төлбөр	Захирал Р.Батсүх, Ерөнхий ня-бо Д.Даваадорж	93,233.44	Төсвийн хууль, тогтоомжийг мөрдөж ажиллах
	Дүн		11,077,378.59	